



### **Маягтыг нөхөх заавар /ХТМ-5/**

Хог хаягдлын мэдээ ХТМ-5-ийг гаргахдаа тухайн хороо, дүүргийн нутаг дэвсгэрт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс гарсан хог хаягдал, нийтийн эзэмшлийн зам талбайгаас цэвэрлэсэн хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх, дарж устгахад гүйцэтгэсэн ажлыг улирлаар, жилийн эхнээс өссөн дүнгээр, тоо ширхэгээр болон зарцуулсан хөрөнгийг тооцож мэдээлнэ.

1. 1-р мөрөнд хот тохижилтын ажлаар нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэсэн талбайг мянган м<sup>2</sup>-д шилжүүлэн бичнэ.
2. 2-р мөрөнд хот тохижилтын байгууллагуудын тээвэрлэсэн хогны хэмжээг мянган м<sup>3</sup>-д шилжүүлэн тооцно. Үүнийг эх үүсвэрээр нь мөр 3-аас мөр 8-д сугалж харуулна.
3. “Дарж устгасан хог”–хэсэгт тээвэрлэсэн хогийг зориулалтыг цэгт асган, дарж устгасан хогны хэмжээг бичнэ. Дарж устгасан хогийг мөн эзэмшлийн төрлөөр сугалж харуулна.
4. “Устгасан нохой”-д эзэнгүй нохойг устгасан тоог бичнэ.
5. Эдгээр үзүүлэлтийг тоо хэмжээ, түүнд зарцуулсан хөрөнгийг улирлаар, жилийн эхнээс өссөн дүнгээр тооцож бичнэ.

Тайлбар : Дээрх ажлуудыг хийхэд зарцуулсан хөрөнгийн дүнд урсгал засварын зардал орохгүй.